амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшгийн эрсдэлийг бууруулах дэд хөтөлбөрийг боловсруулан батлуулж хэрэгжүүлэх.

• Төрийн болон төрийн бус байгууллага иргэдэд зориулсан байгалийн аюул, гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлаар мэдээлэл. мэдээг нэгтгэж, дүн шинжилгээ хийх, түгээх үйл ажиллагааг нэгдсэн тогтолцоонд оруулах мэдээллийн сан байгуулах ажлыг зохион байгуулах, түүнд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг төсөвт суулгах.

• Засгийн газрын болон орон нутгийн гамшгийн нөөц хөрөнгийн хэмжээг тухайн төсөвтэй нь уялдуулан жил болгон тодорхой сан бүрдүүлдэг байх.

• Үндэсний эрсдэлийн сантай болох, хууль эрх зүйн үндсийг бий болгох /Засгийн газрын хуримтлалын сан/

***Л.Билэгдэмбэрэл** — Хууль сахиулахын удирдлагын академийн 821 дүгээр дамжааны суралцагч, онцгой байдлын ахмад*

## ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

***Хураангуй.** Энэхүү илтгэлээр худалдан авах ажиллагааны өнөөгийн удирдлага, зохион байгуулалтыг хууль эрх зүйн орчинд хэрхэн заасан талаар талаар авч үзэхийг зорилоо.*

***Түлхүүр** үг. Худалдан авах ажиллагаа.*

Манай орон зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжээд 20 гаруй жил болж байна. 2000 онд анх батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журмын тухай хуулийн шинэчлэн найруулсан төслийг 2005 онд УИХ-аар хэлэлцэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг баталсан цагаас хойш худалдан авах ажиллагааны орчин бүхий л салбарыг бүрэн хамарч шударга, нээлттэй сонголтыг хийх боломжийг бий болгосон.

Засгийн газар нь батлан хамгаалах, боловсрол, нийгмийн аж байдал, байгалийн нөөцийг эзэмших, эрүүл мэнд, эмнэлэг, зам тээвэр, цагдаа түүнчлэн шуудангийн үйлчилгээ, сансар судлал, хот тохижуулах зэрэг улс олон нийтийн зориулалттай үйл ажиллагааг явуулдаг байгууллагыг багтаадаг томоохон зах зээл бөгөөд дараах онцлогуудыг агуулж байдаг.

> Хувийн хэвшлийнхний хувьд эрхэлж явуулахад хэтэрхий өндөр зардалтай, ашиг олох нь тодорхойгүй, эрсдэлтэй

> Тухайн улс ард түмний нийтлэг ашиг сонирхлыг хамгаалах.

төрийн чиг үүргийг биелүүлэхэд зайлшгүй шаардлагатай

> Нийгмийн чухал эерэг нөлөөтэй, нийгмийн гишүүн бүрт хүрч үйлчлэх хэрэгцээтэй

> Улс орны тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдалтай холбоотой зэрэг салбаруудыг хариуцан ажилладаг бөгөөд эдгээр нь засгийн газрын зах зээлийг бүрдүүлнэ.

2000 оноос өмнө худалдан авах үйл ажиллагааны эрх зүйн үндсийг Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Монгол улсын Засгийн газрын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль. Төсвийн тухай хууль, Иргэний хууль, Үнэт цаасны тухай хууль зэрэг хуулиуд болон Тендерийн журам, Засгийн газрын тогтоол, Менежментийн үр дүнг харгалзан хувьчлан авах этгээдийг сонгон шалгаруулах уралдаант шалгаруулалтын нийтлэг журам (ТӨХ-ны тогтоол)-ууд бүрдүүлж байжээ. Эдгээр хуулиуд нэгдүгээрт, төрийн хөрөнгийг захиран зарцуулах эрхийг хуульчлан баталгаажуулсан хоёрдугаарт тэдгээрийг хэрхэн зарцуулахыг тодорхойлон зохицуулахад чиглэгдсэн байна. Харамсалтай нь Засгийн газрын болон Орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Иргэний хууль, Үнэт цаасны тухай хуулиас бусад нь төрийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдаж авахтай холбогдсон заалтыг өөртөө агуулаагүй. энэ үйл ажиллагааг зохицуулахад чиглэгдээгүй байв. Өөрөөр хэлбэл Монгол улс төрийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохицуулах бие даасан эрх зүйн актгүй явсаар 2000 он хүрчээ. Энэ хугацаанд манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүний бараг гуравны нэг хувьтай тэнцэх хөрөнгө мөнгө бие даасан хуульгүйгээр зарцуулагдаж байсан гэсэн үг. 2000 онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хууль батлагдан гарсанаар засгийн газрын худалдан авах үйл ажиллагааны эрх зүйн үндэс тавигджээ.

Засгийн газрын хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны үндсэн хэлбэр нь олон улсын жишгээр нээлттэй тендер шалгаруулалт зарлах явдал бөгөөд түүнийг хэрэгжүүлэх журам хуулиар хэрхэн зохицуулагдсаныг авч үзье[1]. Уг хуулийн зорилго нь Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгох зорилгоор явуулах тендерийн бичиг баримт боловсруулах, зарлан мэдээлэх, тендерийг нээх, үнэлэх, гэрээ байгуулах эрх

[1] О.Мөнхбат, Х.Март. Төрийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тогтолцоог боловсронгуй болгох нь бодлогын судалгааны тайлан. УБ.

олгох болон тендерийн хорооны бүтэц, зохион байгуулалт, түүний үйл ажиллагаанд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах явдал юм. Хэдийгээр энэ хууль худалдан авах ажиллагаан дахь эрх зүйн саад бэрхшээлийг даван туулахад тодорхой үүрэг гүйцэтгэсэн ч учир дутагдалтай зүйл байгаа нь ажиглагддаг. Тухайлбал:

> Тендерийн босго үнэ тогтоох, тендерийг олон нийтэд ил тод зарлах, тендерийн бичиг баримтыг нээхтэй холбогдсон заалтууд бүрхэг. олон утга агуулснаас тус хуулийн үр өгөөжтэй үйлчлэх боломжийг хязгаарласан байна.

> Босго үнийг шууд зааж, маш бага өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг заавал 3-аас доошгүй газраас үнийн санал авч явуулахаар хуульд тусгасан нь авилга зэрэг сөрөг үзэгдэлтэй тэмцэх оролдлого боловч цаг хугацаа алдах, зохион байгуулалтын зардал хэт өсөхөд нөлөөлсөн.

> Тендерийг төлөвлөх, зарлан явуулах, шалгаруулах, үнэлэх болон чанаргүй бараа, үйлчилгээ нийлүүлэхэд хориг тавих, захиалагчаас тавих хяналт зэрэгтэй холбогдсон хуулийн заалтууд бүрхэг агуулгатай.

> Аливаа тендерийг шудрага явуулах анхдагч нөхцөл бол сонирхогч талуудыг үнэн зөв, бүрэн дүүрэн мэдээллээр жигд хангаж, ил тод нээлтгэй байх зарчмыг хэрэгжүүлэх явдал. Гэтэл одоо үйлчилж байгаа хуулийн тендерийн урилгыг өдөр тутмын сонин болон бусад мэдээллийн хэрэгслээр зарлана гэсэн ерөнхий заалт нь зарыг олонд хүргэх, ингэснээр шударга өрсөлдөөнтэй, ил тод тендер зохион байгуулах боломжийг бүрэн хангаж чадахгүй байжээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай (2011 оны 6 сар) хуульд орсон нэмэлт өөрчлөлтүүдийн нэг нь худалдан авах ажиллагааны бүтэц, зохион байгуулалтын төвлөрлийг сааруулахад оршсон. Аймгуудад ХАА албад байгуулагдснаар аймаг, сумдын ЗДТГ өөрсдөө худалдан авах ажиллагаагаа зохион байгуулах эрхтэй болсон. Түүнчлэн худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах үүднээс ИНБ-ын гишүүд тендерийн үнэлгээний хороонд гишүүнээр ажиллах, гэрээний гүйцэтгэлд хяналт тавих чиглэлээр ажиллах боломжтой болсон юм.

Засгийн газрын худалдан авах ажиллагааны үр өгөөж эл үйл ажиллагаанд оролцогч сонирхогч талуудын идэвхитэй оролцоо. мэргэжлийн чадвар, хариуцлага, зарчимч байр сууринаас олон талаар хамаардаг. Засгийн газрын худалдан авах ажиллагаанд оролцогчийг

> Захиалагч, хэрэглэгч

> Тендерт оролцогчид, гүйцэтгэгчид

> Иргэний нийгмийн байгууллага. олон нийт бүрдүүлнэ.

Захиалагч гэдэг нь Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд. 50 болон түүнээс дээш хувийн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд. Өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.21-д заасан төсөл хэрэгжүүлэгч байна[1]. Захиалагчийг:

Улсын төсвийн хөрөнгө оруулалттай эх үүсвэрээр санхүүжигдэх бараа, ажил. үйлчилгээг худалдан авах захиалагчид бол Ерөнхийлөгчийн болон УИХ-ын тамгийн газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, төрийн захиргааны төв болон УИХ-д ажлаа хариуцан тайлагнадаг байгууллага, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурор, Шүүхийн ерөнхий зөвлөл, Ерөнхий сайд болон Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд байдаг бөгөөд тэд өөрсдийн хэрэгцээнд худалдаж авах бүх бараа, ажил, үйлчилгээний шууд захиалагч юм.

Худалдан авах ажиллагаанд оролцогч талууд

Төрийн худалдан авах ажиллагааг сонирхсон болон тухайн худалдан авалтын явцад шууд ба шууд бусаар хамрагдах, тухайн үйл ажиллагааны ашиг тусыг хүртэх хэн бүхэн оролцогч мөн гэж тодорхойлсон байна[1] [2]. Төрийн худалдан авах ажиллагааны үйл явцад оролцогч талуудыг годорхойлж, тэдгээрийн үүрэг хариуцлагыг оновчтой хуваарилах нь ил тод худалдан авах ажиллагаанд чухал ач холбогдолтой.

Худалдан авалтанд оролцогч талууд гэдэгт худалдан авах ажиллагааг зохион байгуулагч төрийн байгууллагын албан хаагчид болон гүйцэтгэгч хувийн хэвшлийн байгууллага, хуулийн этгээд, хяналт тавих иргэд, иргэний нийгмийн байгууллагыг ойлгоно. Худалдан авалт хариуцсан төрийн албан хаагч энэхүү үйл ажиллагааны үндсэн зарчим болон үе шатуудын талаарх мэдээллийг бүхий л оролцогч талуудад тэгш хүргэж, ил тод байдлаар зохион байгуулах үүрэгтэй. Хэрэгцээг үнэлэхээс эхлээд гэрээг хаах хүртэл бүхий л үе шатанд тэд шууд, шууд бусаар оролцдог байна.

1. **Төр:** Аливаа гэрээ ямар ч тохиолдолд хуулийн хоёр этгээдийн, эсвэл иргэний хооронд хийгддэг. Дэлхийн олон улс оронд яам нь хуулийн этгээд биш байдаг тул худалдан авах гэрээ засгийн газар болон гүйцэтгэгч байгууллагын хооронд хийгддэг. Энэ үед тухайн яамны сайд болон дээд албан тушаалтан засгийн газрыг төлөөлөн гэрээнд гарын үсэг зурах боловч худалдан авах үйл явц, гэрээний хэрэгжилтийг яам дангаараа хариуцан

[1] Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4.1-4.3

[2] Мэрси Кор.Орон нутгийн худалдан авах ажиллагааны сайн туршлагууд.-УБ„ 2015

гүйцэтгэдэг байна.

2. **Хувийн хэвшил:** Улс орны бүх иргэд зам тээврийн тогтолцоо, боловсролын байгууллага, эмнэлгийн үйлчилгээ, дулаан, цахилгаан, цэвэр усны гэх мэт төрийн ажил, үйлчилгээг хэрэглэж байдаг гэдэг утгаараа төрийн худалдан авах ажиллагаанаас ашиг хүртэгчид мөн.

Түүнчлэн хувийн хэвшлийн төлөөлөл худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд саналын эрхтэй оролцох эрхтэй бөгөөд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн гэрчилгээтэй байх шаардлага тавигддаг.

3. **Иргэний нийгмийн байгууллага:** Иргэний нийгмийн чухал бүрэлдэхүүн болох ИНБ нь хэн нэгний юмуу, хэсэг бүлгийн шахалтаар биш. харин сайн дурын зөвшилцөл, сонирхлын үндсэн дээр байгуулагдан ажиллаж, ёс суртахуун нэр хүндэд түшиглэн ажилладгаараа бусад оролцогчдоос ялгаатай. Улс орнуудын орон нутгийн сайн дурын байгууллага, албан бус иргэний байгууллагуудын үйл ажиллагааг тодорхойлохын тулд анх НҮБ, хожим нь олон улсын болон хандивлагч байгууллагууд төрийн бус байгууллага (ТББ) гэсэн нэр томъёог хэрэглэжээ.

Худалдан авах ажиллагааны хувьд үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ажиллах ТББ-ын төлөөлөгчийг сонгохдоо тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ТББ-ын сүлжээнээс санал оруулсан хүнийг сонгодог. ТББ-ын төлөөлөл нь худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн гэрчилгээтэй байх бөгөөд үнэлгээний хорооны хуралдаанд оролцож, санал өгөх эрхтэй байна.

4. **Иргэд:** Төрийн худалдан авах ажиллагаанд иргэд оролцох нь нийгмийн болон хэрэглэгчийн сайн сайхныг дээшлүүлж, төсвийг үр дүнтэй зарцуулж, шинэ санаачилга, шинэтгэл дээр тулгуурласан эдийн засгийг дэмжих, ардчилсан засаглалыг бэхжүүлэхэд тус болдог ажээ .

Төрийн худалдан авах ажиллагааны үйл явцад иргэд оролцох нь нийгмийн болон хэрэглэгчийн хүртэх үр ашгийг дээшлүүлж, төсвийг үр дүнтэй зарцуулж, шинэ санаачилга. улс, орон нутгийнхаа эдийн засгийг дэмжих, ардчилсан засаглалыг бэхжүүлэхэд тус болдгийг туршлага харуулжээ[1]. Худалдан авах ажиллагааны мэдээллийг нийтэд оновчтой, хүртээмжтэй түгээх нь иргэд төрийн худалдан авах ажиллагаанд оролцох, хяналт тавихад дэмжлэг болдог. Орон нутгийн түвшинд худалдан авах ажиллагааны төлөвлөлт, санхүүжилт, үнэлгээний үр дүнтэй тогтолцоо төлөвшөөгүй, мэдээллийн цахим хэрэглээ дутмаг байна. Эдгээрийг засч

[1] Transparencia Mexicana. A new role for citizens in public procurement, [ed.] E Bohorquez. Mexico 2012.

сайжруулах, шийдвэрлэх шаардлага байгаа бөгөөд иргэд, олон нийтийн хяналтын ойлголт. хүрээг тодорхойлох шаардлага ч тулгарсаар байна.

5. **Үнэлгээний хороо:** Аливаа худалдан авах ажиллагааг тухайн захиалагчийн өмнө хариуцан. худалдан авах ажиллагааны журмыг сонгох, тендерийн баримт бичиг боловсруулах, тендерийн урилга зарлах, тендер хүлээж авах. нээх, тендерийн үнэлгээ хийх, үнэлгээ хийхэд зайлшгүй шаардлагатай мэдээллийг олж авах, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох тухай зөвлөмж захиалагчид өгөх, тухайн тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлэх, гэрээ байгуулахад арга зүйн туслалцаа үзүүлэх нь үнэлгээний хорооны гол үүрэг юм.

Үнэлгээний хороог захиалагч байгууллагын даргын шийдвэрээр байгуулна. Үнэлгээний хороо нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ. Үнэлгээний хорооны дарга. нарийн бичгийн даргад төрийн албан хаагчийг томилно. Тухайн байгууллагын худалдан авалт хариуцсан мэргэжилтэн үнэлгээний хорооны гишүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгдөг байвал зохино. Үнэлгээний хороо нь сондгой тооны гишүүдтэй байна.

Худалдан авах ажиллагааны журам олон хувилбартай байж болох ч ерөнхий хэдэн арга л ихэнх тогтолцоонд хүлээн зөвшөөрөгдсөн байдаг. Худалдан авалтын янз бүрийн аргыг хэрэглэж болох ч ямар аргыг хэрэглэх вэ? гэдгийг тодорхойлох гол шалгуур нь босго үнэ юм.

<u>Нээлттэй тендер шалгаруулалт:</u>

Энэ нь худалдан авах ажиллагааг зохион байгуулах үндсэн журам бөгөөд бусад журмуудыг хэрэглэх бодит үндэслэл байхгүй бол худалдан авах ажиллагааг зайлшгүй нээлттэй тендер шалгаруулах журмын дагуу гүйцэтгэхийг шаардана. Хуулиар төсөвт өртгийг үндэслэлгүйгээр хуваан хэд хэдэн тендер зарлахыг хориглосон хэдий ч хэд хэдэн багц бүхий тендер шалгаруулалтыг зөвшөөрсөн бөгөөд ингэхдээ багцуудын төсөвт өртгийн нийлбэр үнийн дүнд үндэслэн холбогдох журмыг сонгохыг заажээ. Нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг олон нийтэд зарлан мэдээлж, сонирхогч этгээдийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангана. Тендерт оролцох сонирхолтой этгээд нь захиалагчаас тогтоосон хугацаанд техникийн болон санхүүгийн саналыг хамтад нь ирүүлнэ. Нээлттэй тендерийн хувьд хоёр үе шаттай шалгаруулалт тендер шалгаруулалт явуулж болно.

Захиалагч хоёр үе шаттай нээлттэй тендер шалгаруулалт явуулах тухайгаа тендерийн баримт бичиг болон урилгад зааж, тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Эхний шатанд тендерт оролцогч нь техникийн саналаа ирүүлэх бөгөөд түүнийг захиалагч үнэлж, нэмж оруулах

тодотгол, өөрчлөлтийг тендерт оролцогчтой тохиролцох; 2-р шатанд тодотгол, өөрчлөлт оруулсан техникийн саналыг үндэслэн хийсэн санхүүгийн саналаа тендерт оролцогч ирүүлэх бөгөөд энэхүү тодотгосон саналыг захиалагч үнэлнэ.

Тендер шалгаруулалтын онцгой журам:

Тендер шалгаруулалтыг онцгой журмаар явуулахдаа хязгаарлагдмал, харьцуулалт, шууд гэрээ байгуулах аргуудыг хэрэглэнэ.

Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгох:

Төсөл зохиох, хэрэгжүүлэх, сургалт явуулах, техникийн туслалцаа үзүүлэх, түүнчлэн судалгаа шинжилгээ хийх, зураг төсөл боловсруулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавихад тусгай мэдлэг, ур чадварын үндсэн дээр гүйцэтгэгчээс үзүүлж байгаа мэргэжлийн үйлчилгээг зөвлөх үйлчилгээ гэнэ. Тухайн зөвлөх үйлчилгээ нь олон салбарын мэдлэг, нарийн мэргэжлийн боловсон хүчин шаардахаар бол хуулийн этгээдийг. энэ үйлчилгээг хувь хүн илүү сайн гүйцэтгэж чадахаар бол хувь хүнийг сонгоно. Захиалагч шаардагдаж байгаа зөвлөх үйлчилгээний зорилт, хүрэх үр дүн болон бусад шаардлагатай мэдээллийг агуулсан ажлын даалгавар бэлтгэж, боловсон хүчний мэргэжлийн чиглэл, түвшин, зөвлөхийн ажлын талбай, төв байранд ажиллах хугацаа, бичиг хэргийн болон тухайн үйлчилгээнд шаардлагатай бусад зардалд үндэслэн төсөвт өртгийг тооцно. Үүний дараа зөвлөхийн жагсаалтад орох саналаа ирүүлэхийг хүссэн урилгыг өдөр тутмын болон бусад хэвлэлд нийтэлнэ.

Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам:

Төрийн худалдан авах ажиллагааны сайн тогтолцоо нь төсвийн зардлын 25 орчим хувийг хэмнэж чадна гэдгийг судалгаа харуулжээ. Энэ их хэмнэлтийг бий болгоход олон нийтийн оролцоо чухал бөгөөд иргэд төрийн худалдан авах ажиллагааны бүх үе шатанд оролцсоноор үргүй зардал, авлигыг олж тогтоох, тэднээс урьдчилан сэргийлэх, тэднийг бууруулах бололцоотой билээ. Хуульд зааснаар 20 сая хүртэл төгрөгийн өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг олон нийтийн оролцоотой худалдан авах нөхцлийг бүрдүүлжээ.

Олон нийтийн оролцоотой зохион байгуулагдах худалдан авах ажиллагаанд оролцохыг хүссэн иргэд Иргэний хуулийн дагуу хамтран ажиллах гэрээ байгуулж, сум, дүүргийн ЗДТГ-т хүсэлтээ гаргана. Хүсэлтэнд үндэслэн иргэдийн бүлгийн жагсаалт гарган, хэвлэл мэдээлэл, цахим хуудсаар дамжуулан иргэдэд нээлттэй байлгана. Жагсаалтанд багтсан гурав ба түүнээс дээш бүлэгт үнийн санал авах урилгыг албан

бичгээр хүргүүлэн товлосон хугацаанд үнийн саналыг хүлээн авч харьцуулалтын аргаар шалгаруулна.

Манай улс зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэн, хөгжиж буй орны хувьд засгийн газрын худалдан авах үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрэн бүрдсэн. Гэхдээ засгийн газрын худалдан авах үйл ажиллагаатай холбоотой хууль эрх зүйн орчинг улам боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага байсаар байна. Өөрөөр хэлбэл худалдан авах үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудын санал бодлыг судлан шийдвэр гаргах түвшинд харгалзан үзэж хууль эрх зүйн баримт бичигт тусгаснаар шударга. нээлтгэй, өрсөлдөөн бий болж, цаг хугацаандаа, илүү чанартай бараа, бүтээгдэхүүн нийлүүлэх бүрэн боломжтой болно.